ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО

“Техно Лизинг” ХХК нь барилгын тоног төхөөрөмж худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Бат-Эрдэнэд өндөр хүчин чадалтай нэгэн цахилгаан үүсгүүрийг үнийг хэсэгчлэн төлөх нөхцөлтэйгөөр худалджээ. Талуудын байгуулсан гэрээнд худалдан авагч үнийг бүрэн төлсний дараа тоног төхөөрөмжийн өмчлөх эрх түүнд шилжихээр тохиролцсон байна.

Бат-Эрдэнэ гэрээ байгуулсны дараа эхний төлбөрийг хугацаанд нь төлсөн боловч дараагийн саруудад төлбөрийн хуваарийг удаа дараа зөрчиж, нийт таван удаагийн төлбөрийг хугацаа хэтрүүлжээ.

Үүнтэй холбогдуулан “Техно Лизинг” ХХК-ийн захирал Бат-Эрдэнэд хандан үлдэгдэл төлбөрийг бүрэн барагдуулах нэг сарын нэмэлт хугацаа тогтоож, энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд гэрээнээс татгалзаж, өмнө төлсөн төлбөрийг буцаан олгож цахилгаан үүсгүүрийг эргүүлэн авахаа мэдэгдсэн байна.

Энэ үед Бат-Эрдэнэ цахилгаан үүсгүүрийн гадна хамгаалалтын их бие гэмтсэнийг засварлуулахаар тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ эрхэлдэг “Их Засвар” ББН-д цахилгаан үүсгүүрийг хүлээлгэн өгсөн байжээ.

Нэмэлт хугацаа олгосон ч төлбөрийн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй тул “Техно Лизинг” ХХК цахилгаан үүсгүүрийг буцаан авахаар “Их Засвар” ББН-д хандахад гүйцэтгэсэн засварын ажлын хөлсийг бүрэн төлөх хүртэл тоног төхөөрөмжийг буцаан өгөхөөс татгалзав.

“Техно Лизинг” ХХК нь Бат-Эрдэнийн захиалгаар хийгдсэн засварын ажилд өөрсдийгөө ямар ч хамааралгүй мөн засварын ажлын гэрээний тал биш тул уг ажлын хөлсийг төлөх үүрэг хүлээхгүй гэдгээ мэдэгдсэн.

Харин “Их Засвар” ББН нь цахилгаан үүсгүүрийн өмчлөх эрх “Техно Лизинг” ХХК-д хэвээр хадгалагдаж байсан учраас засварын ажлыг бодит байдал дээр тус компанийн эд хөрөнгийн ашиг тусын төлөө гүйцэтгэсэн гэж тайлбарлав.

Түүнчлэн Бат-Эрдэнэ нь цахилгаан үүсгүүрийг засварт өгөхдөө өмчлөгчийн ашиг сонирхолд нийцүүлэн, түүний өмнөөс үйл ажиллагаа явуулж буй туслах этгээдийн нэгэн адил оролцсон тул засварын ажлын хөлсийг “Техно Лизинг” ХХК хариуцах ёстой гэж маргажээ.

Асуулт:

1. “Техно Лизинг” ХХК нь “Их Засвар” ББН-өөс цахилгаан үүсгүүрийг буцаан өгөхийг шаардах эрхтэй юу?
2. Энэ тохиолдолд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах боломжтой юу?

Шийдэл:

Асуулт 1: “Техно Лизинг” ХХК нь “Их Засвар” ББН-өөс цахилгаан үүсгүүрийг буцаан өгөхийг шаардах эрхтэй юу?

I. Дээрхи хоёр аж ахуй эрхлэгчийн хооронд ямар нэгэн гэрээ, хэлцэл байгуулагдаагүй учир гэрээнээс үүдэлтэй шаардах эрхийг авч үзэх шаардлагагүй байна.

II. “Техно Лизинг” ХХК нь Иргэний хуулийн 106.1-р зүйлд заасны дагуу шаардлага хэрэгжүүлэх эрхтэй байж болох юм.

1. Үүний тулд “Их засвар” ББН-ийн эзэмшилд машин байх ёстой. Тэрээр машиныг өөрийн мэдэлдээ олж авсан болох нь бодлогын нөхцлөөс харагдаж байна. /машиныг өөрийн бодит мэдэлдээ байлгаж буй ажилтан нь эзэмшигч бус Иргэний хуулийн 89.2-р зүйлд заасан эзэмших эрхгүй этгээд юм./

2. “Техно Лизинг” ХХК нь машины өмчлөгч байх ёстой.

а. Машины анхны өмчлөгч нь “Техно Лизинг” ХХК байсан.

б. Нөгөө талаас машиныг Бат-Эрдэнэд худалдсанаар өмчлөх эрх түүнд шилжсэн байж болох юм. Хэлцлийг тусгаарлах зарчмын дагуу Бат-Эрдэнэ худалдах, худалдан авах гэрээ байгуулсанаар өмчлөх эрх түүнд шилжих бус, харин үнийг бүрэн төлж дууссанаар өмчлөх эрх шилжихээр харилцан тохиролцсон байна.

Үнийг бүрэн төлснөөр өмчлөх эрхийг олж авах гэдэг нь Иргэний хуулийн 112.1-р зүйлд зааснаар болзол тавьж өмчлөх эрхийг шилжүүлэх талаар тохиролцсон байхыг ойлгодог. Энэ тохиолдолд эд юмсыг бодитоор шилжүүлж, эзэмшил үүсэж байгаа боловч өмчлөх эрх болзол биелэгдсэнээр шилждэг. Болзолтойгоор хөрөнгө худалдан авч буй этгээд нь худалдан авч буй зүйлийн үнийг бүрэн төлсөнөөр өмчлөх эрхтэй болох ба тэр хүртэл өмчлөх эрх худалдагчид хадгалагдана. Үнийг бүрэн төлж дуусгах нь өмчлөх эрх олж авах хойшлуулах болзолд / Иргэний хуулийн 44.2-р зүйл/ хамаарна. Үнэ бүрэн төлөгдөж дуусаагүй цагт өмчлөх эрх Бат-Эрдэнэд шилжих боломжгүй.

в. Цааш болсон үйл явдлын дагуу ч “Техно Лизинг” ХХК нь өмчлөх эрхээ алдаагүй байна. Бодлогын нөхцөлд дурдагдсан хугацааны турш “Техно Лизинг” ХХК өмчлөх эрхээ алдсан, түүнтэй холбоотой өөр этгээд өмчлөлдөө олж авсан үйл явдал огт болоогүй байна. Иймээс “Техно Лизинг” ХХК машины өмчлөгч хэвээр үлдсэн.

3. “Их засвар” ББН-ийн хувьд эзэмших эрхтэй эсэх асуудлыг авч үзье. Энэ төрлийн эрх нь гэрээний харилцаанаас үүссэн байж болох юм. “Их засвар” ББН Бат-Эрдэнэтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр эзэмшилдээ олж авч, шууд болон шууд бус эзэмшлийн харилцаа /Иргэний хуулийн 89.3-р зүйл/ үүссэн байна.

а. Гэсэн хэдий ч эзэмшил нь хууль ёсны байхын тулд Бат-Эрдэнэ нь “Техно Лизинг” ХХК-ийн өмнө Иргэний хуулийн 93.1-р зүйлд заасны дагуу эзэмших эрхтэй этгээд

байх шаардлагатай. Бат-Эрдэнэ машиныг засварлуулахаар нөхөрлөлд өгсөн нь “Техно Лизинг” ХХК-ийн өмнө эзэмших эрхтэй этгээд гэж үзэх үндэслэл байж болох юм. Үүнийг шалгаж үзье.

Анх Бат-Эрдэнэ “Техно Лизинг” ХХК-ийн өмнө эзэмших эрхтэй этгээд байсан. Өмчлөх эрх болзолтойгоор олж авах эрх нь шууд бус эзэмшлийн харилцааг бий болгож /Иргэний хуулийн 89.1-р зүйл/, түүний дагуу Бат-Эрдэнэ машиныг ашиглах боломжтой болсон. Ингэснээр Бат-Эрдэнэ Иргэний хуулийн 89.3-р зүйлд заасан шууд эзэмшигч, “Техно Лизинг” ХХК шууд бус эзэмшигч болсон байна. Хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх нь нийтлэг тохиолдолд Иргэний хуулийн 111-р зүйлд зааснаар шилждэг. Харин өмчлөх эрх болзолтойгоор олж авах тохиолдолд Иргэний хуулийн 112-р зүйлийг баримтална. Иргэний хуулийн 112-р зүйлийн дагуу шилжүүлсэнээр нэгэн зэрэг дээр дурдсан шууд бус эзэмшлийн харилцааг үүсгэдэг.

Гэсэн хэдий ч “Техно Лизинг” ХХК /түүнийг төлөөлж захирал,/ худалдах, худалдан авах гэрээнээс татгалзсанаар Бат-Эрдэнийн эзэмшилтэй холбоотой эрх нь дуусгавар болсон байна. Иргэний хуулийн 225.1-р зүйлд зааснаар “Техно лизинг” ХХК ийм эрхтэй бөгөөд бодлогын нөхцлөөс үзвэл үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоож байсан байна. “Техно Лизинг” ХХК нь гэрээнээс татгалзаж буйгаа Иргэний хуулийн 204.1-р зүйлд заасны дагуу мөн мэдэгдсэн. Үүний үр дагаварт Бат-Эрдэнэ эзэмших эрхгүй болсон учир Бат-Эрдэнэ болон нөхөрлөлийн аль аль нь эзэмших эрхгүй этгээдүүд юм.

б. Бат-Эрдэнийн хувьд “ирээдүйд өмчлөх эрх олж авах эрх” үүссэн гэж үзнэ. Энэ төрлийн хөрөнгийн эрх нь өмчлөх эрх болзолтойгоор олж авах тухай тохиролцооноос үүсдэг. Гэвч энэ эрх нь өмчлөгчийн өмнө хэрэгжүүлж болох туйлын эрх мөн үү гэсэн асуулт гарч ирдэг. Цаашилбал Иргэний хуулийн 93.1-р зүйлд заасан эзэмших эрх байгаа эсэхийг тодруулах шаардлагатай. Гэвч энэ бүгдээс өмнө “Техно Лизинг” ХХК худалдах, худалдан авах гэрээнээс татгалзсанаар Бат-Эрдэнийн “ирээдүйд өмчлөх эрх олж авах эрх” мөн дуусгавар болсон байна.

в. “Их засвар” ББН нь Бат-Эрдэнэ болон “Техно Лизинг” ХХК-ийн хоорондын харилцаанаас хамааралгүй, бие даасан эзэмших эрхтэй байж болох юм.

Иргэний хуулийн 354.1-р зүйлд ажил гүйцэтгэгч өөрийн шаардлагыг хангах зорилгоор эзэмшилдээ байгаа, захиалагчийн захиалсан ажлын үр дүн болох хөдлөх эд хөрөнгийг барьцаалах эрхтэй гэж заасан. Энэ нь ажил гүйцэтгэгчид барьцааны эрх хуульд зааснаар үүсэх тусгай зохицуулалт юм.

(1) Ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан эсэх

Бат-Эрдэнэ цахилгаан үүсгүүрийн гадна хамгаалалтын их биеийг засварлуулахаар “Их Засвар” ББН-д хүлээлгэн өгсөн. Нөхөрлөл засварын ажлыг гүйцэтгэхээр хүлээн авсан тул талуудын хооронд Иргэний хуулийн 343.1-р зүйлд заасан ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан байна. Энэ гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл байхгүй.

(2) Ажил гүйцэтгэгчийн шаардлага үүссэн эсэх

“Их засвар” ББН засварын ажил гүйцэтгэсэн бөгөөд ажлын хөлс бүрэн төлөгдөөгүй байна. Иймээс нөхөрлөл нь Бат-Эрдэнээс ажил гүйцэтгэх гэрээний дагуу ажлын хөлс шаардах эрхтэй. Энэ нь Иргэний хуулийн 354.1-р зүйлд заасан барьцаагаар хангагдаж болох шаардлага юм.

(3) Эд хөрөнгө ажил гүйцэтгэгчийн эзэмшилд байгаа эсэх

Цахилгаан үүсгүүрийг Бат-Эрдэнэ засварлуулахаар нөхөрлөлд шилжүүлсэн бөгөөд нөхөрлөл одоог хүртэл эзэмшиж байна. Иймээс энэ нөхцөл хангагдаж байна.

(4) Захиалсан ажлын үр дүн нь хөдлөх эд хөрөнгө мөн эсэх

Цахилгаан үүсгүүр нь хөдлөх эд хөрөнгө бөгөөд түүний гадна хамгаалалтын их биед засварын ажил гүйцэтгэсэн байна. Засварын ажлын үр дүн нь тухайн цахилгаан үүсгүүрт шингэсэн тул уг тоног төхөөрөмжийг Иргэний хуулийн 354.1-р зүйлд заасан захиалсан ажлын үр дүн болох хөдлөх эд хөрөнгө гэж үзнэ.

(5) Барьцааны зүйл гуравдагч этгээдийн өмчлөлийн хөрөнгө байж болох эсэх

Цахилгаан үүсгүүрийн өмчлөгч нь “Техно Лизинг” ХХК боловч ажил гүйцэтгэх гэрээний захиалагч нь Бат-Эрдэнэ байна. Иргэний хуулийн 354.1-р зүйлийн үгчилсэн агуулгаар захиалагч нь барьцааны зүйлийн өмчлөгч байхыг шууд шаардаагүй. Түүнчлэн энэ зүйлийн шинжлэх ухааны тайлбарт ажил гүйцэтгэгчийн барьцааны эрхийн зүйл нь захиалагчийн өөрийн өмчлөлийн төдийгүй гуравдагч этгээдийн өмчлөлийн эд хөрөнгө байж болохоор тусгасан байна. Үүний дагуу бол Бат-Эрдэнэд барьцааны эрх үүссэн тул ажлын хөлсийг төлөх хүртэл цахилгаан үүсгүүрийг шилжүүлэхээс татгалзах эрхтэй байна.

Гэхдээ захиалагч бус гуравдагч этгээдийн өмчлөлийн эд хөрөнгөд өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр ямар ч нөхцөлд барьцааны эрх үүсэж болно гэж үзэж болох уу. Иргэний хуулийн 354.1-р зүйлийг өмчлөх эрхийн халдашгүй байдал, барьцааны эрхийн эд хөрөнгийн эрх зүйн шинж болон үүргийн харилцааны харьцангуй үйлчлэх зарчимтай уялдуулан тайлбарлах шаардлагатай гэж үзэж байна.

а. Өмчлөгчийн эрхийг хамгаалах зарчмын үүднээс авч үзвэл:

Барьцааны эрх нь бусдын эд хөрөнгөд тогтоох хязгаарлагдмал хөрөнгийн эрх бөгөөд өмчлөгчийн эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хязгаарлах үр дагавартай. Түүнчлэн барьцаагаар хангагдсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломжтой. Иймээс барьцааны эрх үүсэх нь өмчлөгчийн эд хөрөнгийн эрх зүйн байдалд шууд нөлөөлнө.

Хэрэв захиалагч өөрийн өмчлөлийн бус эд хөрөнгийг засварлуулахаар өгсөн төдийд ажил гүйцэтгэгч тухайн эд хөрөнгөд барьцааны эрх олж авна гэж үзвэл захиалагч нь өөрийн байгуулсан гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдийн өмчлөх

эрхийг хязгаарлах боломжтой болно. Ингэснээр өмчлөгч нь өөрөө байгуулаагүй, зөвшөөрөөгүй гэрээний үүргийн гүйцэтгэлийг өөрийн эд хөрөнгөөр хангах эрсдэл хүлээнэ. Гуравдагч этгээдийн өмчлөх эрхийг ийнхүү хязгаарлахын тулд хуульд хангалттай тодорхой үндэслэл байх шаардлагатай. Иймээс 354.1-р зүйлийг өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эд хөрөнгөд барьцааны эрх үүсгэх ерөнхий зөвшөөрөл гэж өргөн тайлбарлах нь өмчлөх эрхийг хамгаалах зарчимтай нийцэхгүй гэж үзэж байна.

б. Ажил гүйцэтгэх гэрээний үүргийн харилцааны үүднээс авч үзвэл:

Ажил гүйцэтгэх гэрээнээс үүсэх ажлын хөлс төлөх үүргийг захиалагч хүлээнэ. Иргэний хуулийн 354.1-р зүйлд заасан барьцааны эрхийн зорилго нь ажил гүйцэтгэгчийн гэрээнээс үүссэн шаардлагын биелэлтийг хангахад оршино. Өөрөөр хэлбэл барьцааны эрх нь ажил гүйцэтгэгчийн гэрээний шаардлагыг хангах нэмэлт баталгаа юм. Гэвч гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах энэ арга хэрэгсэл нь тухайн гэрээнд оролцоогүй гуравдагч этгээдийн өмчлөх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарлах ёсгүй. Хэрэв захиалагч өөрийн өмчлөлийн бус эд хөрөнгийг ажил гүйцэтгэгчид шилжүүлсэн бол уг үйлдэл нь дангаараа өмчлөгчийг захиалагчийн гэрээний үүргийн төлөө эд хөрөнгийн хариуцлага хүлээхэд хүргэх үндэслэл болохгүй. Иймээс 354.1-р зүйлд заасан барьцааны эрхийг гэрээний үүрэг хүлээж буй захиалагчийн өмчлөлийн эд хөрөнгөд үүсэхээр хязгаарлан тайлбарлах нь үүргийн харилцааны мөн чанарт илүү нийцнэ.

в. Барьцааны эрхийг шударгаар олж авах зохицуулалттай уялдуулан авч үзвэл:

Иргэний хуулийн 154.6-р зүйлд барьцааны эрхийг шударгаар олж авахтай холбоотой зохицуулалт тусгагдсан. Гэвч уг зохицуулалтыг Иргэний хуулийн 354.1-р зүйлд заасан хуульд үндэслэн үүсэх барьцааны эрхэд шууд хэрэглэх боломжтой эсэх нь тусдаа асуудал юм. Хэлцлийн үндсэн дээр барьцааны эрх үүсэхэд талууд барьцааны эрх тогтоох хүсэл зоригоо илэрхийлдэг бол ажил гүйцэтгэгчийн хуульд заасан барьцааны эрх нь талуудын барьцааны тухай тусгай тохиролцоогүйгээр үүсдэг. Иймээс барьцааны эрхийг шударгаар олж авах тухай зохицуулалтыг хуульд заасан барьцааны эрхэд шууд хэрэглэвэл гуравдагч этгээдийн өмчлөх эрхийг түүний хүсэл зоригоос үл хамааран хязгаарлах хүрээ өргөжих эрсдэлтэй.

Захиалагч эд хөрөнгийг эзэмшиж байсан явдал нь түүнийг өмчлөгч гэж тооцох итгэлээс илүүтэйгээр өмчлөгчийн эрх хамгаалагдах ёстой. Иймээс 154.6-р зүйлийг үндэслэн 354.1-р зүйлд заасан барьцааны эрхийг шударгаар олж авсан гэж үзэх боломжгүй.

Иргэний хуулийн 354.1-р зүйлийг өмчлөгчийн эрхийг хамгаалах, үүргийн харилцаа харьцангуй байх болон хөрөнгийн эрхийг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах зарчимтай уялдуулан тайлбарласнаар ажил гүйцэтгэгчийн барьцааны эрхийг зөвхөн захиалагчийн өмчлөлийн эд хөрөнгөд үүсэхээр хязгаарлах нь үндэслэлтэй гэж үзэж байна. Иймээс нөхөрлөл нь “Техно Лизинг” ХХК-ийн өмчлөлийн цахилгаан үүсгүүрт Иргэний хуулийн 354.1-р зүйлд заасан барьцааны эрх олж аваагүй байна.

Улмаар нөхөрлөл нь уг барьцааны эрхэд үндэслэн Иргэний хуулийн 93.1 дүгээр зүйлд заасан, өмчлөгчийн эсрэг хэрэгжүүлэх эзэмших эрхтэй гэж үзэх боломжгүй байна.

Иймээс “Техно Лизинг” ХХК нь Иргэний хуулийн 106.1-р зүйлд үндэслэн цахилгаан үүсгүүрийг нөхөрлөлөөс буцаан шаардах эрхтэй.

Иргэний хуулийн 354.1, 154.6-р зүйлийн хэрэглээний хүрээнд шалгуулагч гуравдагч этгээдийн өмчлөлийн эд хөрөнгөд барьцааны эрх үүсэх эсэх талаар аль нэг байр суурийг үндэслэлтэй хамгаалсан бол зөвхөн дүгнэлт нь загвар шийдлээс өөр байгаагаар оноо хасахгүй байх нь зүйтэй гэж үзэж байна.

Асуулт 2: Энэ тохиолдолд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авах боломжтой юу?

“Техно Лизинг” ХХК нь “Их Засвар” ББН-д холбогдуулан цахилгаан үүсгүүрийг буцаан гаргуулах нэхэмжлэл гаргасан тул уг эд хөрөнгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаанд бусдад шилжүүлэхээс сэргийлэх зорилгоор шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах боломжтой байж болох юм.

1. Хүсэлт гаргах эрх

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1 дэх хэсэгт зааснаар шүүгч нэхэмжлэгчийн хүсэлтийг үндэслэн хэрэг үүсгэхдээ буюу үүсгэсний дараа шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авч болно.

Энэ тохиолдолд “Техно Лизинг” ХХК нь цахилгаан үүсгүүрийг буцаан гаргуулах нэхэмжлэлийн шаардлага гаргасан бөгөөд маргаан бүхий эд хөрөнгө “Их Засвар” ББН-ийн эзэмшилд байна.

Иймээс нэхэмжлэгч нь шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах эрхтэй.

2. Шаардлага байгаа эсэх

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээний зорилго нь нэхэмжлэлийн шаардлагыг урьдчилан хангах бус, харин шүүхийн шийдвэр гарсны дараа түүнийг бодитоор биелүүлэх боломжийг хадгалахад оршино. Энэ бодлогын хувьд нэхэмжлэлийн зүйл нь цахилгаан үүсгүүр. Иймээс уг тоног төхөөрөмжийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдад шилжүүлэх, худалдах, зөөвөрлөх, нуух, эсхүл эд ангийг нь салгах тохиолдолд шүүхээс гарах шийдвэрийг биелүүлэхэд хүндрэл учирч болзошгүй. Бодлогын нөхцөлөөс үзвэл “Их Засвар” ББН нь засварын ажлын хөлс төлөгдөөгүй гэх үндэслэлээр цахилгаан үүсгүүрийг буцаан өгөхөөс

татгалзсан байна. Гэвч эд хөрөнгийг буцаан өгөхөөс татгалзсан явдал нь түүнийг бусдад шилжүүлэх, нуух, эсхүл шүүхийн шийдвэрийн биелэлтэд саад учруулах гэж байгаа болохыг дангаараа нотлохгүй.

Иймээс баталгаажуулах арга хэмжээ авах бодит шаардлага байгаа эсэхийг маргаан бүхий эд хөрөнгийн шинж, эзэмшлийн байдал болон шүүхийн шийдвэрийн биелэлтэд учирч болзошгүй хүндрэлтэй холбон үнэлэх шаардлагатай.

3. Төрлийг тодорхойлох нь

а. Хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1.1 дэх заалтад хариуцагчийн эд хөрөнгө буюу мөнгийг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжлэх арга хэмжээг зохицуулсан. Гэвч маргаан бүхий цахилгаан үүсгүүр нь “Их Засвар” ББН-ийн өмчлөлийн хөрөнгө биш, харин “Техно Лизинг” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгө юм. Иймээс уг цахилгаан үүсгүүрийг хариуцагчийн эд хөрөнгө гэж үзэн 69.1.1 дэх заалтын дагуу битүүмжлэх боломжгүй.

б. Эд хөрөнгөтэй холбоотой тодорхой ажиллагаа явуулахыг хориглох

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1.2 дахь заалтад хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой тодорхой ажиллагаа явуулахыг хориглох арга хэмжээг зохицуулсан. Энэ тохиолдолд “Их Засвар” ББН нь цахилгаан үүсгүүрийн өмчлөгч биш боловч уг эд хөрөнгийг бодитоор эзэмшиж байна. Иймээс нөхөрлөл цахилгаан үүсгүүрийг бусдад шилжүүлэх, худалдах, барьцаалах, эсхүл гуравдагч этгээдийн эзэмшилд өгөх боломжтой бөгөөд эдгээр үйлдэл нь шүүхээс гарах шийдвэрийн биелэлтэд хүндрэл учруулж болзошгүй. Иймд “Техно Лизинг” ХХК нь 69.1.2 дахь заалтад үндэслэн цахилгаан үүсгүүртэй холбоотой тодорхой ажиллагаа явуулахыг хариуцагчид хориглуулах хүсэлт гаргаж болно.

в. Тодорхой ажиллагаа гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.1.5 дахь заалтад тодорхой ажиллагаа гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхгүй байхыг хариуцагчид даалгах арга хэмжээг зохицуулсан. Энэ заалтын дагуу “Техно Лизинг” ХХК нь цахилгаан үүсгүүрийг одоогийн байршлаас зөөвөрлөхгүй байх, эд ангийг нь салгахгүй байх, бусдад хүлээлгэн өгөхгүй байх зэрэг тодорхой үйлдэл хийхгүй байхыг нөхөрлөлд даалгуулах хүсэлт гаргах боломжтой. Ийм арга хэмжээ нь маргаан бүхий цахилгаан үүсгүүрийн одоогийн байдлыг хадгалж, шүүхийн шийдвэрийг биелүүлэх боломжийг хамгаалахад чиглэнэ. Түүнчлэн хуулийн 69.2 дахь хэсэгт зааснаар шаардлагатай тохиолдолд хэд хэдэн баталгаажуулах арга хэмжээг нэгэн зэрэг авч болно.

4. Нэхэмжлэлийн шаардлагад тохирсон байх

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ нь нэхэмжлэлийн шаардлагын шинж, хэмжээ болон хамгаалах зорилгод нийцсэн байх шаардлагатай. Энэ бодлогын хувьд нэхэмжлэгч нь тодорхой нэг цахилгаан үүсгүүрийг буцаан гаргуулахыг шаардаж байгаа тул хариуцагчийн бүх эд хөрөнгийг битүүмжлэх, банкны дансны зарлагын хөдөлгөөнийг зогсоох зэрэг арга хэмжээ авах нь нэхэмжлэлийн шаардлагатай нийцэхгүй. Харин зөвхөн маргаан бүхий цахилгаан үүсгүүрийг бусдад шилжүүлэх, зөөвөрлөх, эд ангийг нь салгах зэрэг үйлдлийг хориглох нь нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд тохирсон арга хэмжээ болно. Түүнчлэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69.5 дахь хэсэгт заасан шаардлагыг харгалзан хариуцагчийн үйлдвэрлэл, үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд шаардлагагүй хязгаарлалт учруулахгүй байх ёстой.

5. Хүсэлтийг шийдвэрлэх нь

Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авахуулах хүсэлт гаргасан нь шүүгч уг хүсэлтийг заавал хангах үндэслэл болохгүй. Шүүгч нь хүсэлтийн үндэслэл, маргаан бүхий эд хөрөнгийн шинж, шүүхийн шийдвэрийн биелэлтэд хүндрэл учрах эрсдэл болон хүссэн арга хэмжээний тохирсон байдлыг харгалзан шийдвэрлэнэ. Бодлогын нөхцөлд нөхөрлөл цахилгаан үүсгүүрийг бусдад шилжүүлэхээр завдсан тухай баримт байхгүй боловч уг эд хөрөнгийг буцаан өгөхөөс татгалзсан байна. Иймээс шүүх нь зөвхөн буцаан өгөхөөс татгалзсан нөхцөлд үндэслэн бус, тухайн эд хөрөнгийг бусдад шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх бодит шаардлага байгаа эсэхийг үнэлж, баталгаажуулах арга хэмжээ авах эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО ОНООНЫ ХУВААРИЛАЛТ

Д/д	**Эрх зүйн харилцаа**	**Хэрэглэх хууль, эрх зүйн дүгнэлт**	**Өгвөл зохих оноо**
1	“Техно Лизинг” ХХК болон Бат-Эрдэнэ нарын хооронд үүссэн харилцаа	ИХ-ийн 243.1, 225.1, 204.1, 262.1 Гэрээнээс татгалзсанаар Бат-Эрдэнийн эзэмших эрх дуусгавар болсон. Үүргийн харилцаа болон өмчлөх эрхий харилцааг тусгаарлах зарчмын дагуу тайлбарласан байх.	5

2	Бат-Эрдэнэ болон “Их засвар” ББН-ийн хооронд үүссэн харилцаа	ИХ-ийн 343.1, 354.1, 89.2, 89.3, 154.1, 114.1, 112.1, Хийвэл зохих дүгнэлт: Барьцааны эрхийг шударгаар олж авсан эсэхийг тайлбарласан байх, өмчлөгчийн эрхийг хамгаалах зарчим тайлбарлах замаар “Их засвар” ББН-ийн эзэмшлийг хууль бус гэж тодорхойлсон байх.	8
3	“Техно лизинг” ХХК болон “Их засвар” ББН-ийн хооронд үүссэн харилцаа	Талуудын хооронд гэрээний харилцаа байхгүйг тогтоох, Шаардах эрхийн үндэслэлийг тодорхойлох, ИХ-ийн 106.1-ийг хэрэглэсэн байх.	5
4	ИХШХШтХуулийн 69.1-ийг хэрэглэсэн байх	ИХШХШтХ-ийн 69.1 дэх хэсгийн дагуу баталгаажуулах арга хэмжээ авхуулах хүсэлт гаргах эрхийг тогтоох 69.1.1 дэх заалтын дагуу хариуцагчийн өмчлөлийн бус эд хөрөнгийг битүүмжлэх асуудлыг ялгах 69.1.2, 69.1.5 дахь заалтын дагуу эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, худалдах, зөөвөрлөхийг хориглуулах боломжийг тодорхойлох Шийдвэрийн биелэлтэд хүндрэл учрах эрсдэл, арга хэмжээний тохирсон байдлыг үнэлж дүгнэх	2
Нийт оноо			**20**

---ooOoo---